

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2022 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/05/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Эрдэнэт хот

2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.06 № 01

танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА
М.ЧУЛУУНЗАГД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Анхан шатны баримтын бүрдэл хангах, түүнд хяналт хэрэгжүүлсэн байдал нь үр нөлөөгүй байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэлээр илэрч байна.

Мөн Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус газрын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт дотоод аудитаар “сайжруулах хэрэгтэй” дүгнэлт өгсөн байна.

Аудитын гол асуудал

Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2 арга хэмжээний хүрээнд 7 зорилт, 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр, мэдлэг чадвар дээшлүүлэх болон төрийн албан хаагчийн нийгмийн баталгаагаар хангах төлөвлөгөөг тус тус газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг 93.1 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээнд улсын төсвөөс 143,409.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 142,109.3 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, 1,300.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.1 хувьтай байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ голын сав газрын захиргаа нь үйл ажиллагаанд ашиглаж буй 1 авто тээврийн хэрэгслийн өмчлөгчийн бүртгэлийг 2018 оноос хойш шилжүүлээгүй, 2022 оны 1 сард хүлээн авсан авто тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгөд бүртгэх шийдвэрийг гаргуулаагүй, санхүүгийн тайлангийн толилуулгад толилуулаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,584,210.00	33,739,300.00
33	АВЛАГА	2,149,110.00	
335	Бусад авлага	2,149,110.00	
3351	Байгууллагаас авах авлага	2,149,110.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	34,435,100.00	33,739,300.00
351	Түүхий эд материал	33,547,900.00	33,041,500.00
35110	Тусгай зориулалттай материал	33,547,900.00	33,041,500.00
354	Хангамжийн материал	887,200.00	697,800.00
35410	Бичиг хэргийн материал	862,200.00	672,800.00
35420	Аж ахуйн материал	25,000.00	25,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,467,052.41	7,817,865.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,467,052.41	7,817,865.25
392	Биет хөрөнгө	14,467,052.41	7,817,865.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,959,500.00	11,959,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,659,916.72	-7,319,833.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,600,000.00	15,600,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,933,333.28	-13,266,666.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,559,370.84	6,559,370.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,058,568.43	-5,714,505.59
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	51,051,262.41	41,577,165.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	51,051,262.41	41,577,165.25
51	Засгийн газрын хувь оролцоо	51,051,262.41	41,577,165.25
512	Хуримтлагдсан үр дүн	51,051,262.41	41,577,165.25
51210	Өмнөх үеийн үр дүн	51,051,262.41	48,902,152.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-7,344,987.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	51,051,262.41	41,577,165.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	246,263,186.00	173,217,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,259,500.00	392,220.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,259,500.00	392,220.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/		
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	244,003,686.00	172,825,080.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	176,289,400.00	143,409,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	176,289,400.00	143,409,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,714,286.00	29,415,480.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,000,000.00	26,515,480.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	2,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,000,000.00	300,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	248,862,689.02	180,562,287.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	248,862,689.02	180,562,287.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	218,054,432.96	178,961,978.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,860,277.00	105,957,883.57
210101	Үндсэн цалин	68,173,600.00	79,488,100.00
210102	Нэмэгдэл	21,057,317.53	20,755,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,629,359.47	5,714,583.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,611,415.64	13,685,266.43
210201	Тэтгэврийн даатгал	8,687,515.64	9,430,982.13
210202	Тэтгэмжийн даатгал	981,000.00	1,064,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	784,800.00	850,661.18
210204	Ажилгүйдлийн даатгал	196,100.00	212,665.39
210205	Эрүүл мэндийн даатгал	1,962,000.00	2,126,657.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,504,400.00	9,256,772.00
210304	Байрны түрээс	11,142,000.00	9,256,772.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,458,973.30	16,795,784.50
210401	Бичиг хэрэг	9,826,780.00	2,356,500.00
210402	Тээвэр, шатахуун	28,821,786.00	12,270,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,236,207.30	1,010,584.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	574,200.00	652,300.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	506,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,063,200.00	2,912,000.00
210604	Урсгал засвар	3,885,000.00	2,912,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,382,800.00	3,463,400.00
210702	Дотоод албан томилолт	3,382,800.00	3,463,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,082,690.00	18,577,585.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,565,200.00	17,962,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	160,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,490.00	135,645.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	253,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,090,677.02	8,313,287.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,415,000.00	1,664,100.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,490,677.02	6,649,187.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,808,256.06	1,600,308.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,415,356.06	1,600,308.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,415,356.06	1,600,308.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-2,599,503.02</u>	<u>-7,344,987.16</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>165,762,525.00</u>	<u>172,825,080.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	165,762,525.00	172,825,080.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	151,245,400.00	143,409,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	151,245,400.00	143,409,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,517,125.00	29,415,480.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,515,480.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,517,125.00	300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>164,682,525.00</u>	<u>172,825,080.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	164,682,525.00	172,825,080.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,796,739.16	171,224,771.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,250,524.00	105,957,883.57
210101	Үндсэн цалин	75,253,688.00	79,488,100.00
210102	Нэмэгдэл	15,934,507.00	20,755,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,062,329.00	5,714,583.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,727,195.12	13,685,266.43
210201	Тэтгэврийн даатгал	8,803,577.06	9,430,982.13
210202	Тэтгэмжийн даатгал	980,905.24	1,064,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	784,724.07	850,661.18
210204	Ажилгүйдлийн даатгал	196,181.17	212,665.39
210205	Эрүүл мэндийн даатгал	1,961,807.58	2,126,657.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,038,500.00	9,256,772.00
210304	Байрны түрээс	11,038,500.00	9,256,772.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,746,955.04	15,707,764.50
210401	Бичиг хэрэг	954,200.00	2,167,100.00
210402	Тээвэр, шатахуун	8,862,125.00	11,877,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,248,632.04	1,010,584.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	681,998.00	652,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,810,050.00	2,912,000.00
210604	Урсгал засвар	3,632,000.00	2,912,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,846,500.00	3,463,400.00
210702	Дотоод албан томилолт	4,846,500.00	3,463,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,757,115.00	18,577,585.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,360,000.00	17,962,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	179,820.00	160,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,295.00	135,645.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	66,000.00	253,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,619,900.00	1,664,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,419,900.00	1,664,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,885,785.84	1,600,308.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,885,785.84	1,600,308.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,885,785.84	1,600,308.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,080,000.00</u>	<u>00.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,080,000.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			42,469,923.57	42,469,923.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			42,469,923.57	42,469,923.57
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C07	Тайлант үеийн үр дүн			8,581,338.84	8,581,338.84
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			51,051,262.41	51,051,262.41
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			51,051,262.41	51,051,262.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(2,149,110.00)	(2,149,110.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			48,902,152.41	48,902,152.41
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D08	Тайлант үеийн үр дүн			-7,344,987.16	-7,344,987.16
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			41,577,165.25	41,577,165.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	143,409,600.00	142,109,291.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	143,409,600.00	142,109,291.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143,409,600.00	142,109,291.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	105,992,600.00	105,957,883.57
210101	Үндсэн цалин	79,488,100.00	79,488,100.00
210102	Нэмэгдэл	20,755,200.00	20,755,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,749,300.00	5,714,583.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,738,400.00	13,685,266.43
210201	Тэтгэврийн даатгал	9,481,300.00	9,430,982.13
210202	Тэтгэмжийн даатгал	1,064,300.00	1,064,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	851,400.00	850,661.18
210204	Ажилгүйдлийн даатгал	212,900.00	212,665.39
210205	Эрүүл мэндийн даатгал	2,128,500.00	2,126,657.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,279,100.00	9,256,772.00
210304	Байрны түрээс	9,258,400.00	9,256,772.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,510,500.00	6,510,484.50
210401	Бичиг хэрэг	212,900.00	212,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,739,500.00	4,739,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,010,600.00	1,010,584.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	547,500.00	547,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,912,400.00	2,912,000.00
210604	Урсгал засвар	2,912,400.00	2,912,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,527,600.00	1,507,400.00
210702	Дотоод албан томилолт	1,527,600.00	1,507,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	784,900.00	615,385.00
210803	Даатгалын үйлчилгээ	295,800.00	160,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,500.00	135,645.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	92,500.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	260,100.00	253,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1664100.00	1664100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,664,100.00	1,664,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	143,409,600.00	143,409,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	143,409,600.00	143,409,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	143,409,600.00	143,409,600.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	9	9
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7
620003	Үйлчлэх ажилтан	1	1

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 18,873.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 18,873.3 мянган төгрөгийн алдааг залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд: Авто тээврийн хэрэгслийн урсгал засварын сэлбэг, сургалтын цай, тэмдэгжүүлэх самбар зэргийг бараа материалын дансанд бүртгэхгүйгээр зардалд бүртгэсэн, 2016 онд улсын төсөвт төвлөрүүлсэн санхүүжилтийг авлагаар бүртгэж, одоог хүртэл шийдвэрлүүлээгүй, тайлант оны санхүүгийн тайлан, тодруулга, толилуулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв тайлагнаагүй, иж бүрдлийг бүрэн хангуулаагүй аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 10,181.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 2,800.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3,662.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 3,718.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Шатахууны зарцуулалтыг нормоор хянаагүйгээс илүү олгож, зарцуулсан тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлээгүй, хэмнэлт үүсгэж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй 1 авто тээврийн хэрэгслийн өмчлөгчийн бүртгэлийг 2018 оноос хойш шилжүүлээгүй, 2022 оны 1 сард хүлээн авсан авто тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгөд бүртгэх шийдвэрийг гаргуулаагүй, тайлант оны санхүүгийн тайлангийн толилуулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв тайлагнаагүй, иж бүрдлийг бүрэн хангуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 6.6.2-т "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 2-т "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна" гэж заасантай нийцэхгүй, аудитын иж бүрэн байх, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Автомашины өмчлөл, бүртгэлийн асуудлыг шийдвэрлүүлж, санхүүгийн тайлан, тодруулга, толилуулгыг хууль, журам, стандартад нийцүүлэн гаргаж, баталгаажуулж байх.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажил үйлчилгээ худалдан авахдаа цахим төлбөрийн баримтгүй бүртгэж, албан томилолтын хуудсыг бүрэн хөтлөөгүй, бүрдлийг хянаагүй, жолоочийн тооцооны хуудсыг өдөр бүр бус нийт дүнгээр хөтөлсөн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т "аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5-д "анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна байна байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг бичгээр болон цахимаар холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэхийг хянаж, баталгаажуулж байх.

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын даргын шийдвэргүй, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр бараа материал акталсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 2-т "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна" гэж заасантай нийцэхгүй, аудитын толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материал акталж устгах шийдвэрийг гаргаж, өмч хамгаалах байнгын зөвлөлийг чиг үүргийн дагуу ажиллуулж, хяналтыг сайжруулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сэлэнгэ голын сав газрын захиргаа	3	18,873.3			3	18,873.3	3	18,873.3			1	
Дүн	3	18,873.3			3	18,873.3	3	18,873.3			1	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сэлэнгэ голын сав газрын захиргаа	3	6,519.2	1	2,800.8			2	3,718.4				
Дүн	3	6,519.2	1	2,800.8			2	3,718.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Сэлэнгэ голын сав газрын захиргаа	1								1	
Дүн	1								1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Сэлэнгэ голын сав газрын захиргаа	1	3,662.6			1	3,662.6				
Дүн	1	3,662.6			1	3,662.6				
Нийт дүн	2	3,662.6			1	3,662.6			1	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			